



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/055/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Утас: 7000-77348	Ч.Болд Цахим хаяг: bold@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Утас: 3155588 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	Х.Түвшинбаяр
	Аудитын менежер Утас: 325093	Я.Алтанцэцэг Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал Утас: 99884842	А.Сарангэрэл Цахим хаяг: gereltekhburtgelaudit06@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/339
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР ДЭВШИЛ
МЕНЕЖМЕНТ ААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ГАНХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь 2024 оны "Хог тээвэрлэлт, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээг хийлгэх тухай" А/112 дугаар захирамжаар СБД-ийн 12 дугаар хорооны хог тээвэрлэлт болон зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцаж эхэлснээр 92 аж ахуйн нэгж, байгууллага, 836 айл өрх нэмэгдсэн байна.

Тайлант онд Сүхбаатар дүүргийн 5 хорооны 704 аж ахуйн нэгж байгууллага, хорооллын 3102 айл өрхийн, орон сууцны 5728 айл өрхийн хог хаягдлыг хог тээврийн 8 машинаар 7139 рэйс 19,609 тонн Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

СБД-ийн ИТХ-ын ээлжит 9 дүгээр хуралдаанаар баталсан "Үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 9/51 дүгээр тогтоолын дагуу гэр хороолол, орон сууцны айл өрхийн хог хураамжийн төлбөрийг нэмэгдүүлсэн байна.

C:\Users\zendene\Desktop\2025\Word\1\aan bich\2025.03.19 Suxbaatar d...menegemjg.docx 1425010221

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 хөтөлбөрийн 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр бүрэн хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	183,723,541.39	1,059,383,779.70
1.1.2	Дансны авлага	40,180,500.00	11,502,080.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.6	Бараа материал	59,136,992.72	141,177,268.15
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	8,400,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	283,041,034.11	1,220,463,127.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,566,551,408.14	1,690,743,343.55
1.2.2	Биет бус хөрөнгө	35,738,356.16	35,911,643.82
1.2.3	Дуусаагүй барилга	21,105,221.23	21,105,221.23
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,602,289,764.30	1,747,760,208.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,885,330,798.41	2,968,223,336.45
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	439,600.00
2.1.1.3	Татварын өр	23,840,107.19	49,097,650.13
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	313,775,392.25	268,529,944.43
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	337,615,499.44	318,067,194.56
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Хойшлогдсон орлого	1,162,654,613.70	1,201,289,295.88
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,162,654,613.70	1,201,289,295.88
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,500,270,113.14	1,519,356,490.44
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,000,000.00	11,000,000.00
2.3.5	Хуримтлагдсан ашиг	374,060,685.27	1,437,866,846.01
2.3.6	Эздийн өмчийн дүн	385,060,685.27	1,448,866,846.01
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,885,330,798.41	2,968,223,336.45

1.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,127,924,935.54	2,502,511,417.59
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	1,127,924,935.54	2,502,511,417.59
8	Бусад орлого	1,050,123,997.14	1,944,204,875.64
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,651,755,882.46	2,787,366,909.10
10	Ерөнхий ба удирдлагын зардал	260,949,939.19	451,411,494.53
12	Бусад зардал	29,066,039.10	25,931,044.34
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	236,277,071.93	1,182,006,845.26
19	Орлогын татварын зардал	23,627,707.19	118,200,684.52
20	Татварын дараах ашиг (алдагдал)	212,649,364.74	1,063,806,160.74
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	212,649,364.74	1,063,806,160.74
1,063,24	Орлогын нийт дүн	212,649,364.74	1,063,806,160.74

1.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	161,411,320.53	161,411,320.53
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	212,649,364.74	212,649,364.74
7	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,000,000.00	374,060,685.27	385,060,685.27
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	1,063,806,160.74	1,063,806,160.74
13	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,000,000.00	1,437,866,846.01	1,448,866,846.01

1.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,932,252,646.54	4,155,141,860.59
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,104,739,435.54	2,535,018,847.59
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,859,961.00	4,148,613.00
	Татаас, санхүүжилтийн орлого	815,000,000.00	1,615,974,400.00
	Бусад мөнгөн орлого	7,653,250.00	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,763,234.433.08	3,090,747,352.28
	Ажиллагчдад төлсөн	1,077,033,057.45	2,025,613,886.02
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	139,997,167.39	257,208,744.03
	Бараа материал худалдан авахад төлсөн	172,200,252.00	189,300,278.00
	Ашиглалтын зардалд төлсөн	19,749,821.53	16,457,420.25
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	283,471,086.65	407,919,126.43
	Татварын байгууллагад төлсөн	3,175,397.32	94,114,743.55
	Даатгалын төлбөрт төлсөн	18,194,413.00	17,057,074.00
	Бусад мөнгөн зарлага	49,413,237.74	83,076,080.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	169,018,213.46	1,064,394,508.31
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	85,980,500.00	188,734,270.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	84,550,500.00	187,084,270.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,430,000.00	1,650,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(85,980,500.00)	(188,734,270.00)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	83,037,713.46	875,660,238.31
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,685,827.93	183,723,541.39
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	183,723,541.39	1,059,383,779.70

1.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
1	ААН орлого	594,282,978.0	646,578,120.0	717,749,413.6	71,171,293.6	111.1
2	ХҮТ / орон сууц/	31,531,000.0	226,187,360.0	107,532,680.0	(118,654,680.0)	47.5
3	Гэр хороолол	59,594,185	183,189,039.0	222,297,464.0	39,108,425.0	121.3
4	Зам талбайн цэвэрлэгээ 6,9,14,16 хороо орлого	389,364,773.0	1,358,031,860.0	1,358,031,860.0		- 100.0
5	Иргэдийн бүлэг	53,152,000.0	96,900,000.0	96,900,000.0		- 100.0
6	Татаас санхүүжилт	785,000,000.0	1,615,974,400.0	1,615,974,400.0		- 100.0
7	Бусад орлого	235,123,997.1	328,230,475.6	328,230,475.64	0.04	100.0
8	Зах-А/503 Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд СБД.ЗДТГазар	30,000,000.0	-	-		-
Нийт дүн		2,178,048,932.7	4,455,091,254.6	4,446,716,293.23	(8,374,961.4)	99.8
1	Цалин хөлс	1,057,693,519.3	2,313,182,910.0	1,979,088,440.0	334,094,470.0	85.6
2	Нийгмийн даатгалын шимтгэл	139,997,167.0	299,570,169.6	256,882,632.0	42,687,537.6	85.8
3	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	1,584,835.0	2,000,000.0	959,051.0	1,040,949.0	48
4	Бичиг хэргийн зардал	5,137,810.0	15,000,000.0	7,986,562.4	7,013,437.6	53.2
5	Ашиглалтын зардал	19,549,821.0	53,500,000.0	15,116,320.3	38,383,679.8	28.3
6	Хангамжийн материалын зардал	32,648,650.0	75,000,000.0	61,307,123.3	13,692,876.7	81.7
7	Аж ахуйн материал	15,822,126.0	58,000,000.0	56,258,130.5	1,741,869.5	97
8	Сургалтын зардал	-	10,000,000.0	3,005,000.0	6,995,000.0	30.1
9	Түрээс. тээвэр зардал /автомашин, тоног төхөөрөмж/	-	87,500,000.0	79,075,574.0	8,424,426.0	90.4
10	Тогтмол үйлчилгээ, засварын зардал	39,325,354.0	50,000,000.0	32,283,250.0	17,716,750.0	64.6
11	Шатахуун тос тослох материалын зардал	218,613,202.0	355,000,000.0	238,949,361.0	116,050,639.0	67.3
12	Даатгалын зардал	18,156,997.0	22,000,000.0	19,766,825.0	2,233,175.0	89.8
13	Утас, интернэтийн зардал	1,280,331.0	2,200,000.0	2,117,444.5	82,555.5	96.2
14	Томилолтын зардал /унаа, буудал, хоол/	26,720,000.0	35,000,000.0	28,500,000.0	6,500,000.0	81.4
15	Хэвлэлийн зардал	2,449,700.0	4,000,000.0	1,424,120.0	2,575,880.0	35.6
16	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалын зардал	18,760,000.0	50,000,000.0	40,723,300.0	9,276,700.0	81.4

17	Банкны үйлчилгээний зардал	116,933.0	750,000.0	112,400.0	637,600.0	15
18	Цэвэрлэгээний материалын зардал	15,010,778.0	-		-	0
19	бусад зардал	29,066,039.1	20,000,000.0	10,179,305.1	9,820,694.9	50.9
20	Тусгай зориулалтын давс, бодис		276,750,000.0	59,270,000.0	217,480,000.0	21.4
24	Элэгдэл,хорогдолын зардал	180,424,676.3	209,063,825.7	209,063,825.7	-	100
25	Хөдөлмөр хамгааллын зардал	36,199,600.0	80,000,000.0	51,776,580.9	28,223,419.2	64.7
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	20,634,556.0	79,250,000.0	43,382,200.0	35,867,800.0	54.7
27	Сэлбэг хэрэгслийн зардал	60,717,484.0	100,000,000.0	65,166,057.9	34,833,942.1	65.2
28	Онцгой байдлын зардал	1,862,282.0	19,337,850.0	2,315,944.3	17,021,905.7	12
Нийт дүн		1,941,771,860.8	4,217,104,755.3	3,264,709,447.97	952,395,307.4	77.4
1	Татварын өмнөх ашиг/алдагдал	236,277,071.9	237,986,499.3	1,182,006,845.3		
2	Орлогын албан татвар	23,627,707.2		118,200,684.5		
3	Цэвэр ашиг/алдагдал	212,649,364.7		1,063,806,160.7		
5	Хөрөнгө оруулалт	146,878,200.0		174,200,000.0		
8	Нийт авлага	40,180,500.0		19,902,080.0		
9	Нийт өр төлбөр	23,840,107.2		49,537,250.1		
10	Нийт худалдан авалт	621,831,022.9		180,334,270.0		

2. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 8,400.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тээврийн хэрэгсэлтэй холбоотой зардлыг үйл ажиллагааны мөнгөн зардлаар бүртгэж, тайлагнаагүй	1	8,400.0	1		1	8,400.0	1	8,400.0	-	-	-	-
Дүн	1	8,400.0	1		1	8,400.0	1	8,400.0	-	-	-	-

Аудитаар нийт 21,885.2 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 780.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 21,105.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд урамшуулал олгосон	1	780.0	1	780.0	-	-	-	-	-	-	-	-
Дуусаагүй барилга дансанд ашиглалтанд орсон үндсэн хөрөнгө бүртгэлтэй, НӨХГ шийдвэр ирүүлээгүй	1	21,105.2	-	-	-	-	1	21,105.2	-	-	-	-
Байгууллагын нэр дээр бүртгэлтэй хөрөнгийн шилжилт, хөдөлгөөнийг хийж, бүртгэлд тусгаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	3	21,885.2	1	780.0	1	-	2	21,105.2	-	-	-	-

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,172,219.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	1,035,862.2	-	-	1	1,035,862.2	-	-
Дүн	1	1,035,862.2	-	-	1	1,035,862.2	-	-
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил								
Хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй олж бэлтгэсэн	1	17,702.6	-	-	-	-	1	17,702.6
Дүн	1	17,702.6	-	-	-	-	1	17,702.6
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөөгүйгээс ХҮТ хариуцсан орлого тасарсан	1	118,654.8	-	-	-	-	1	118,654.8
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргасан боловч хууль журамд нийцүүлэн зохион байгуулж гүйцэтгээгүй	1	-	-	-	-	-	1	-
Ахмадуудад холбогдох хуульд заасан дэмжлэг үзүүлээгүй	1	--	-	-	-	-	1	--
Дүн	3	118,654.8	-	-	-	-	3	118,654.8
Нийт дүн	5	1,172,219.6	-	-	1	1,035,862.2	4	136,357.4



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14

№ 121/14915266

Улаанбаатар хот

НТАГ- 2025/055/НА-СТА-ОНӨУГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын 2024 оны Б/141, Б/143 тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 2 ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулалд 780,000.00 (долоон зуун наян мянган) төгрөг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрөөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1.Сахилгын шийтгэлтэй ажилтанд олгосон урамшууллын 780,000.00 төгрөгийг суутган, Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх ;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын Гүйцэтгэх захирал С.Ганхуяг, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхмандах нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН
ГЭРЭЛТЭХ БҮРТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

ХЯНАСАН:
САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

А.САРАНГЭРЭЛ

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1105050170



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 424/14925266

Улаанбаатар хот

НТАГ - 2025/055/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 212,560,529.00 (хоёр зуун арван хоёр сая таван зуун жаран мянга таван зуун хорин есөн) төгрөгийн орлогын 14 гүйлгээ, зарлагын 823,301,656.83 (найман зуун хорин гурван сая гурван зуун нэг мянга зургаан зуун тавин зургаан төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй хугацаа хоцроосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх төрийн аудитын газар¹-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын Гүйцэтгэх захирал С.Ганхуяг, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхмандах даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

ГЭРЭЛТЭХ БҮРТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

А.САРАНГЭРЭЛ

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040497